



БАТЛАВ
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ”
ТӨХК-ИЙН ГҮҮЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ш.БАЯНМОНХ

9020030414 6021646

БАТЛАВ
ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ СУДАЛГААНЫ
ТӨВИЙН ЗАХИРАЛ

Л. БЯМБАА

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ



2022 оны 04 сарын 25-ны өдөр

№ 52/2022

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн захиалгаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.8, Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм 11 дүгээр зүйлийн дагуу ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх мэдлэг ур чадварыг сайжруулж аваар ослоос урьдчилсан сэргийлэх зорилгоор сургалт зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахаар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1. Энэхүү гэрээгээр сургалтын хуваарь, төлбөр, сургалтад хамрагдах ажилтны тоо зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөт зардлын хэмжээнд тохируулж Захиалагч байгууллагатай харилцан зөвшилцсөн сургалтын хөтөлбөр батлах бөгөөд уг хөтөлбөр нь энэхүү гэрээний нэгдүгээр хавсралтаар баталгаажна.
- 2.3. Энэхүү гэрээ нь 2022 оны 04 дүгээр сарын 15-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 26-ний өдрийг дуусталх хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгднө.

Хоёр. Захиалагч талын эрх, үүрэг

- 3.1. Захиалагч тал нь сургалтын байгууллагын боловсруулсан сургалтын хөтөлбөртэй танилцах, сургалтын хуваарийн дагуу ажилтнуудаа сургалтад хамруулна.
- 3.2. Батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт явуулахыг шаардах, цагийн хуваарийн дагуу явуулж байгаа эсэхэд хяналт тавина.
- 3.3. Захиалагч талаас сургалтын чанар, сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол саналыг гаргана.
- 3.4. Сургалтын хөтөлбөрийг зөвхөн сургалтын үйл ажиллагаанд ашиглах бөгөөд бусдад дамжуулахгүй байх үүрэгтэй.

3.5. Сургалтын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх.

Гурав. Сургалтын байгууллагын эрх, үүрэг

- 3.1. Батлагдсан хөтөлбөр, цагийн хуваарийг нарийн баримталж сургалт зохион байгуулна.
- 3.2. Захиалгат сургалт нь нийт 2 цагаар 2 удаа ээлжийн 4 ээлжийн нийт 108 ажилтанд зохион байгуулагдах бөгөөд сургалтын нэг цагийг 45 минутаар тооцож зохион байгуулна.
- 3.3. Сургалтыг захиалагчийн хүсэлтийн дагуу батлагдсан хөтөлбөрөөр цахим болон танхим, мөн дадлага хийх хэлбэрийг хослуулан чанартай зохион байгуулна.
- 3.4. Ажилтны мэдлэгийн түвшинг бататгах, бүлэг бүрийн дараа сургалтын агуулгаар ярилцлага, дадлага хийх ажлыг зохион байгуулна.
- 3.5. Сургалтын хуваарыт өөрчлөлт орвол урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1. Гэрээнд заагдсан асуудлаар талуудын хооронд маргаан үүсвэл, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх ба зөвшилцөлд эс хүрвэл Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

Тав. Төлбөрийн нөхцөл

- 5.1. Гэрээний нийт ажлын хөлс нь 1100000 /нэг сая нэг зуун төгрөг /НӨАТ-гүй/ болно. Энэхүү ажлын хөлсийг гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 30 хоногт багтаан Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны эрдэм шинжилгээ, сургалт судалгааны төвийн ХААН банкны 5037727584 тоот дансанд шилжүүлнэ.
- 5.2. Аль нэг тал нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө талдаа урьдчилан албан бичгээр мэдэгдэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулна.

Зургаа. Бусад зүйл

- 6.1. Гэрээгээр зохицуулаагүй аливаа харилцааг Монгол Улсын хуулийн дагуу зохицуулна.
- 6.2. Энэхүү гэрээг талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.3. Гэрээг гурван хувь үйлдэх бөгөөд захиалагч тал 2 хувь, гүйцэтгэгч тал 1 хувийг авна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ХАНГАМЖ ЭРЖЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ
Б.УРТНАСАН

САНХҮҮ ~~Б.~~ ЭДИЙН ЗАСГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ө.УДВАЛ

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
П.ЗОРИГОО

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХАБЭА-Н ИНЖЕНЕР
А.ЭНХЖАРГАЛ

Хаяг: БЗД 8-р хороо УС-15-1-1
Утас: 77111152

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХЭМАББО ЭШССТӨВИЙН СУРГАЛТЫН
МЕНЕЖЕР

C. Монхтуяа С. МӨНХТУЯА

Хаяг: УБ хот Баянгол дүүрэг, 8-р хороо
Намсрайн гудамж, Эрдэм цогцолбор 101
тоот
РД:8321515
Утас: 88046078



**“ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙ - 2022” 14 ХОНОГИЙН АЯНЫ ХҮРЭЭНД
ХИЙГДЭХ НИЙТ АЖИЛГЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Сургалтын зорилго. Ажилнуудад аюулгүй ажиллах, ажлын байрны серег хүчин зүйлсээс зруул мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н тухай ойлголт болон хууль эрх зүйн талаарх мэдлэгийг дээшилүүлж болзошгүй аюул, эрдэл осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх арга барил хандлагыг төлөвшүүлэхэд оршино.

Хугацаа: 2022 оны 04 дугаар сарын 18, 25-ны 09:00-11.00 цагт,

Зах багш: Сэтгэл зүйч Т. Түмэн-өлзий

№	Сэргэв	Салбарын асуулт	Хугацаа /минутын/
1	Хандлага	<ul style="list-style-type: none"> - Хандлага гэж юу вэ? - Эрүүл, аюулгүй ажиллах, амьдрах зан үйл, хандлагыг төлөвшүүлэхийн ач холбогдол - Ажлын байрны зохион байгуулалт, эмх цэгц 	20
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн зохицуулалт	<ul style="list-style-type: none"> -ХАБЭА-н тухай үндсэн ойлголт -ХАБЭА-н тухай хууль болон холбогдох хууль тогтоомжуудын холбогдох заалтууд -Байгууллагын ХАБЭА-н удирдлага зохион байгуулалт 	20
3	Ажлын байран дах серег хүчин зүйлс болон аюул тэдгээрийг таньж илрүүлэх, мэдээллийх	<ul style="list-style-type: none"> -Серег хүчин зүйлс, тэдгээрийн ангилал, урьдчилан сэргийлэлт - Ажлын байран дах осол, евчлэлд хургэх хүчин зүйлс тэдгээрийг таньж мэдэх, мэдээллийх - Хамгаалах хэрэгсэл, түүний төрөл, зохистой хэрэглээ 	20
<i>Заварлага /10 минут/</i>			
4	Цахилгааны аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> -Цахилгааны тухай ойлголт, аюул эрдэл -Цахилгаан болон гар багаж хэрэгсэл, тооног төхөөрөмжтэй харьцах үсийн аюулгүй ажиллагааны шаардлагууд -Цахилгаанаас үүдэлтэй бөртэл, гэмтэл, анхны тусламж 	20
5	Галын аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> -Галын аюулгүй байдлын тухай ойлголт -Гал унтраах хэрэгсэл, түүний хэрэглээ -Гал гарсан үед авах арга хэмжээ -Онцгой байдлын үед авах арга хэмжээ 	20
6	Анхны тусламж	<ul style="list-style-type: none"> -Ослын газарт нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээ -Анхны тусламжийн зарчим, төрлүүд 	10
	Асуулт, хариулт		10

ХЯНАСАН: ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА:

П.ЗОРИГОО

БОЛОВСРУУЛСАН:ХАБЭА ИНЖЕНЕР

А.ЭНХЖАРГАЛ